

**"АРИГ БАНК" ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН
Д.ТҮВШИНТАМИРЫН 04 ДҮГЭЭР УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН**

2021 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот


Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 5176 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1-т заасны дагуу 2021 оны 04 дүгээр улирлын ажлын тайланг хүргүүлж байна. Ариг банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь тайлант хугацаанд нийт 6 удаа хуульд заасны дагуу танхимаар, цахимаар, эчнээ санал хураалтын хэлбэрээр хуралдаж, Төлөөлөн удирдах зөвлөлөөс дараах тогтоол, шийдвэрүүдийг гарган ажилласан байна. Үүнд:

1. 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хурлаар "Ариг Банк" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хойшлогдсон хурлын даргаар ТУЗ-ийн гишүүн бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хорооны дарга С.Сайнбатыг томилох асуудлаар санал хураалт явуулж шийдвэрлэсэн.
2. 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хурлаар ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны даргын хувьд хурлыг зарлан хуралдуулж, Хууль, тусгай активын хэлтсээс ӨБХ-ийг худалдан борлуулах, үнэ тогтоох асуудлыг хэлэлцүүлэхээр оруулж ирснийг дараах байдлаар шийдвэрлэв.
 1. Баянзүрх дүүрэг, 1-р хороо, 21-63 тоот хаяг бүхий газрыг 57 сая төгрөгөөр худалдах үнийн саналыг Хууль, тусгай активын хэлтсээс гаргасныг 1 м.кв нь 2 сая төгрөгөөр тооцож, 64 сая төгрөгөөр худалдан борлуулах үнийг тогтоох шийдвэр гаргасан.
 2. Баянгол дүүрэг, 2-р хороо, 26-32 тоот газрыг зээлийн төлбөрт тооцон төлснийг нь зээлдэгчийн зүгээс мөнгөн хэлбэрээр өр төлбөрөө төлсөн нөхцөлд өмчлөгчид нь буцаан өгөх шийдвэрийг гаргасан.
 3. Баянгол дүүрэг, 22-р хороо, Зүүн наран, 13-р гудамжны 160 тоот 180 м.кв хувийн орон сууц, 700 м.кв газрын хамт хөрөнгийн үнэлгээгээр 22,000,000 төгрөг гэж үнэлсэн.
 4. Иргэн Д.Зориг нь тооцоо нийлсэн актаар 1,457,000,000 төгрөгийн өртэй гэсэн тооцоо гарсан ба түүний нэр дээрх 48 хөрөнгийг аваад зээлийг хаах санал тавих эсвэл хамтран дуудлага худалдаагаар хөрөнгийг худалдаж, зээлийг хаах санал тавих гэх зэрэг асуудлыг хэлэлцсэн ба Эрсдэлийн хорооны зүгээс тусгай активын хэлтсээс оруулах саналтай танилцан шийдвэр, дүгнэлт, зөвлөмж гарган ажилласан.
3. 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэжээ.
 1. "Ариг Банк" ХХК-ийн 2021 оны үйл ажиллагаанд аудит хийх талаар санал авч, тухайн аудитыг хийх мэргэжлийн байгууллагыг сонгох тухай
 2. Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчийн хүсэлтийг шийдвэрлэх, түүнд олгосон чөлөөг сунгах эсэх тухай
 3. Банкны суурь бүртгэлийн систем хэрэгжүүлэх төслийн танилцуулга болон гэрээ байгуулах тухай
 4. Компанийн эд хөрөнгийн үнэлгээг Компанийн тухай хуульд заасны дагуу шийдвэрдэх тухай асуудлыг ТУЗ-ийн нийт гишүүдэд танилцуулах зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

4. 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо цахимаар хуралдаж дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Үүнд:
 1. "Ариг банк" ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд аудит хийх хөндлөнгийн аудитын компанийг сонгох, үнийн саналыг хэлэлцэх, компанийг төлөөлөн гэрээ хэлцэл хийх эрхийг олгох асуудал болон хэлэлцэн шийдвэрлэв.
 2. "Ариг банк" ХХК-ийн дүрмийн санг 100 тэрбум төгрөгт хүргэх асуудлаар ХЭХ-ийн зарлах, хурлын товыг гаргах тухай
5. 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Аудитын хорооны хуралд оролцож, Аудитор сонгох тухай асуудлыг хэлэлцэж шийдвэрлэв.
6. 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдөр Эрсдэл удирдлагын хорооны гишүүн П.Мөнх-Эрдэнэ, Ш.Баярсайхан нарын хамт дараах асуудлын хүрээнд хуралдаж, тогтоол гарган ажилласан байна.
 1. Иргэн Г.Мөнхзулаар үлдэгдэл төлбөр болох 6,7 сая төгрөгийг төлүүлж, гэрээ байгуулах тухай
 2. Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт орших зочид буудлын зориулалтаар ашиглаж буй объектын үнэлгээг 1,410,000,000 төгрөгөөр батлан, 8%-иар бууруулан худалдан борлуулах тухай асуудлыг ТУЗ-ийн хурлаар оруулах тухай
7. 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн ТУЗ-ийн хурлаар дараах асуудлыг шийдвэрлэсэн болно. Үүнд:
 1. Хувьцаа эзэмшигч "Улаанбаатар импекс" ХХК нь хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт оруулан, компанийн нэмж гаргасан хувьцааг ТУЗ-ийн мэдэгдэлд заасан хугацаанд тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлж, саналаа ирүүлсэн тул энэхүү асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, Монгол банкинд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг ихэсгэх тухай албан бичгийг хүргүүлэхээр батласан.
 2. Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Ариунжаргалын 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл чөлөө хүссэн асуудлыг шийдвэрлэж, түүнийг орлох этгээдийг томилсон шийдвэрийг гаргасан.
 3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр хуралдуулахаар товлон, хэлэлцэх асуудлыг батлаж шийдвэрлэв.

ТАЙЛАН БИЧСЭН:

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн

 Д.Түвшинтамир/